



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ЦЭВГЭЭГИЙН ОТГОНБАЯР ТАНАА**

2024.09.03 № ТМДТ-2024/13-АУТА-КА-91

танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигч Цэвгээгийн Отгонбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа,

мэдээллийг тус тус шалгуур болгосон.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Цэвгээгийн Отгонбаяр /РД:МП79072262/-ын Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Цэвгээгийн Отгонбаярын мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.


Хувийг: Хүдэр сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЦЭВГЭЭГИЙН
ОТГОНБАЯРЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



Хөтөлбөрийн зорилго: Хүн амын хөгжлийн үндсэн чиглэл болох боловсрол, хувь хүний хөгжилд өөрийн мэдлэг чадвараа зориулан иргэдээс гарсан санал санаачилгыг хэрэгжүүлэх, иргэдийн дуу хоолойг шийдвэр гаргах байгууллагын түвшинд хүргэж, орон нутгийнхаа хүүхэд залуусын дуу хоолой болж ажиллахад оршино.

Зорилт: Хүн бүрийг чанартай боловсролд тэгш хамруулах, идэвхтэй, эрүүл амьдралын хэв маягтай иргэн, гэр бүлийг дэмжих, иргэдэд амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

1. Цахим сургалтаар боловсрол эзэмших боломж, орчин нөхцөлийг сайжруулах бодлогыг дэмжинэ.

2. Иргэд, олон нийт, суралцагчдад Үндэсний монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

3. Биеийн тамир, спортоор хичээллэх, бие бялдараа чийрэгжүүлэх орчин, нөхцлийг хүүхэд, залуучууд, иргэн бүрд хүртээмжтэй хэлбэрээр хөгжүүлэх бодлогыг дэмжинэ.

4. Соёл, урлаг, угийн бичгийг хөтлөх, хөгжүүлэх, сурталчлан таниулах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санал санаачилга гаргаж, хамтарч ажиллана.

5. Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлнэ.

6. Хувь хүнд чиглэсэн үйлчилгээнүүдийг хөгжүүлэх, ахуйн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлийн үйл ажиллагааг дэмжинэ.

7. Иргэд амьдрах орчин нөхцлөө сайжруулах талаар зохион байгуулсан арга хэмжээ болон нийтийн эзэмшлийн талбайд мод тарьж ургуулах санал санаачилга гарган хамтран ажиллана.

8. Хүүхэд, залуучуудын хөдөлмөр амралтын зусланг шинээр байгуулах иргэд, олон нийтийн санал санаачлагыг дэмжиж, холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.